



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comsol@iaac.mn, http://iaac.mn

2020-01-10 № 05/371  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Зөвлөмж, чиглэл хүргүүлэх  
тухай

Тус газраас Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт тавин ажиллаж байна.

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтнууд хуулийн үйлчлэлд хамаарч нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн тохиолдолд тус газраас нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /цаашид ХАСУМ гэх/-ийг хянаж, холбогдох дүгнэлтийг гарган хүргүүлж байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоол, 2018 оны 335 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.4-2.11-т зааснаар төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх этгээдийг томилох, чөлөөлөх, удирдамж чиглэл өгөх эрхийг Засгийн газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг байгууллагууд хэрэгжүүлэхээр зохицуулсан бөгөөд улмаар төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагад томилогдох нийтийн албан тушаалтны ХАСУМ-ийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасныг үндэслэн тус газраар хянуулж байна.

Дээрх хяналтаар 2017-2019 онуудад төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтнаар томилогдохоор нэр дэвшсэн нийт 1055 нэр дэвшигчийн ХАСУМ-ийг тус газраас хянаж хариуг хүргүүлснээс тухайн албан үүргийг гүйцэтгэхэд илт ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал тогтоогдсон- 1, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүйг анхааруулсан -98, хуульд заасан үндэслэлээр буцаасан-70, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй гэж-892 нэр дэвшигчийн талаарх дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн байна. Үүнээс ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүйг анхааруулсан нийт 98 байгаагаас:

1. Албан тушаалын тодорхойлолт болон хуульд заасан шаардлага хангаагүй 46,
2. Ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсныг анхааруулсан 42,
3. Ашиг сонирхлын зөрчилтэй гэх ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон 10 тус тус байна.

Мөн тус газраас нэр дэвшигчийн мэдүүлгийг хянан үзэхдээ томилогдохоор нэр дэвшсэн байгууллага болон харьяа салбар нэгжид түүний эрхлэх асуудлын хүрээнд шууд



болон шууд бусаар нөлөөлөх хүчин зүйл байгаа эсэх, түүнчлэн гэр бүлийн болон хамаарал бүхий этгээдийн шууд захирах, захирагдах ажлын байранд томилогдож байгаа эсэх, ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдох хувь хүн хуулийн этгээд байгаа эсэх, тухайн ажлын байранд тавигдах болзол шаардлагыг хангасан, зохих журмын дагуу сонгон шалгаруулалтад хамрагдсан болон салбарын хууль, тогтоомжийг зөрчих асуудал байгаа эсэхийг хянан үздэг.

Хянан шалгасан материалаас харахад төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээд болон удирдах албан тушаалтныг томилохдоо нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалт зарлалгүйгээр шууд томилдог, албан тушаалын буюу ажлын байрны тодорхойлолтыг тухайн томилогдох этгээд, хувь хүнд зориулан субъектив байдлаар боловсруулдаг, мөн ХАСУМ хянуулахаар ирүүлж буй материалын бүрдэл хангалтгүй, түүнчлэн авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөмтгий тушаал, шийдвэр захиран зарцуулах эрх хэмжээтэй компанийн эрх бүхий албан тушаалтнуудыг хуулийн үйлчлэлд бүрэн хамруулдаггүй зэрэг нийтлэг зөрчилтэй байна. Тухайлбал: "Эрдэнэс Монгол" ХХК нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлого мэдүүлэг гаргагчийн нэрсийн жагсаалтыг Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд /компанийн дэд захирлууд/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ерөнхий нягтлан бодогч нар байхаар батлан мэдүүлэг гаргуулж байх боловч тус компанийн 8 газрын захирал, 2 албаны дарга болон ерөнхий аудитор зэрэг бусад удирдах албан тушаалтнуудыг бүрэн хамруулаагүй байна.

Мөн хянан шалгасан тоон үзүүлэлт, судалгааны дүнгээс харахад албан тушаалын тодорхойлолт болон ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт болон боловсрол, мэргэжил, ажлын туршлага зэрэг хуульд заасан шаардлага хангаагүй нэр дэвшигчийг томилуулахаар ирүүлсэн үзүүлэлтээр "Эрдэнэт" ТӨҮГ, "Төрийн банк" "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК зэрэг байгууллагууд нь бусад байгууллагаас өндөр хувийг эзэлж байна.

Түүнчлэн тус газрын Мөрдөн шалгах хэлтсээс Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй холбоотой 2016 онд 112, 2017 онд 168, 2018 онд 82, 2019 онд 66, нийт 428 албан тушаалтанд холбогдох авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шалгасан нь нийт албан тушаалын гэмт хэрэгт холбогдогчийн 20 гаруй хувийг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдах албан тушаалтнууд эзэлж байгаа нь ажлын байранд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт хангаагүй этгээдийг томилдог, томилогдсон албан тушаалтнууд нь хувийн сонирхолдоо нийцүүлэн албаны бүрэн эрхээ хэрэгжүүлдэг, цаашлаад авлигын гэмт хэрэгт өртөх эрсдлийг бий болгож байна.

Иймд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албанд томилогдох этгээдийн сонгон шалгаруулалтыг ил тод нээлттэй болгох, албан тушаалтны үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу дараах "ЗӨВЛӨМЖ"-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.2 "нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх" гэж заасныг баримтлан төрийн болон, төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгжийн удирдах болон эрх бүхий албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, улмаар ажлын байрны тодорхойлолтыг /албан тушаалын тодорхойлолт/-ыг эрхлэх асуудал, ажлын байрны чиг үүрэг, албан тушаалд тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварт нийцүүлэн нэгдсэн стандартын дагуу боловсруулж мөрдүүлэх.



2. Нийтийн албаны томилгоо, сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгож, иргэнийг хуульд заасан болзол журмын дагуу нийтийн албанд орох адил тэгш боломжоор хангах, нийтийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах.

3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.5.13-т "хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтны хүрээг оновчтой тогтоож, мөрдөх" гэж заасныг хэрэгжүүлж авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөмтгий ажил албан тушаал эрхэлдэг төрийн болон, төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн нэгж, түүний харьяа хараат болон охин компаниудын удирдах болон эрх бүхий албан тушаалтнуудыг хуулийн үйлчлэлд бүрэн хамруулах чиглэлээр харьяалах салбар нэгжид хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулах.

4. Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтнууд хуулийн үйлчлэлд хамаарах бөгөөд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.", 84.2-т "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна." гэж заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчит компанийн дүрэмд төсөв, хөрөнгө захиран зарцуулах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, эрх олгох, цуцлах, түдгэлзүүлэх, бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулж шалгаруулах зэрэг шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа удирдах болон эрх бүхий албан тушаалтныг бүрэн хамруулах арга хэмжээ авах.

5. Удирдах албан тушаалтны манлайлал, ёс зүйн байдлыг дээшлүүлэх, ялангуяа төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан улмаар авлига албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгэгдсэн этгээдийг нийтийн ажил, албан тушаалд томилохгүй байх, дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах.

6. Нийтийн албан тушаалтны давхар ажил эрхлэлтэд тавих хяналтыг сайжруулах, энэ төрлийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр давхар ажил эрхлэлттэй холбоотой ажил, үүргийг гүйцэтгэхгүй байх, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг баримтлан ажиллахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авах.

7. Төсөв, санхүү худалдан авах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, бусдад давуу байдал олгох, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах буюу хамаарал бүхий этгээд, нэгдмэл сонирхолтой этгээдтэй холбоотой тушаал, шийдвэр гаргах, гаргахад оролцох, гэрээ хэлцэл байгуулах, албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөх зэрэг авлига, ашиг сонирхлын зөрчлийг гаргахгүй байх, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах зэрэг болно.

Түүнчлэн дээрх зөвлөмж, чиглэлийг харьяалах төрийн болон, төрийн өмчийн оролцоотой компани, аж ахуйн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж, удирдах албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар өөртөө болон бусдад давуу байдал олгож буй үйлдлийг таслан зогсоох, тэдгээрийн ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах ёс зүйн хяналтын хороо, салбар хороог байгуулах, тэдгээрийн уялдаа холбоог хангах, үнэлгээ дүгнэлт өгөх, авсан арга хэмжээний талаар олон нийтэд

ил тод мэдээлж хэвшүүлэх зэргээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай болно.

Мөн Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийг үндэслэн дээрх зөвлөмж чиглэлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжилт, үр дүн, биелэлтийн талаар 2020 оны 03 дугаар сарын 01-ний дотор тус газарт хариу ирүүлнэ үү.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР